



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 183/ШШ2019/00698

Улаанбаатар хот

ГХариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснийг
баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Мөнгөнтуул би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж, Ньюмайнд групп ХХК-ийн байранд оршин байрлах, Лэндмн ББСБ ХХК /РД:5039754/-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Хан-Уул дүүргийн 02 дугаар хороо, 19 хороолол, 28 байр, 34 тоотод оршин суух, Гавьж овогт Бямбаагийн Дорждэрэм /РД:ШУ92091914/-д холбогдох,

Гэрээний үүрэгт 205 000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч, 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр иргэний хэрэг үүсгэн хянаад,

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Билгүүн нь шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “..Бямбаа овогтой Дорждэрэм нь Лэндмн ББСБ ХХК-ийн нэхэмжилсэн 205 000 төгрөгийг төлж барагдуулсан тул шүүхэд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзаж байна” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХХК нь хариуцагч Б.Дорждэрэмд холбогдуулан гэрээний үүрэгт 205 000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч Б.Дорждэрэм нь нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХХК-ийн нэхэмжилсэн 205 000 төгрөгийг төлж нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлсэн болох нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбараар тогтоогдож байх тул хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр 74.5 дахь хэсэгт хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тал хувиар бууруулж тогтоох ба түүнийг энэ хуульд заасан журмын дагуу гаргуулна, 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “..хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө” гэж тус тус зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 6 800 төгрөгийг улсын орлогод үлдээж, хариуцагчаас 3 400 төгрөгийг, Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн 2603030349 тоот данснаас 3 400 төгрөгийг тус тус гаргуулан нэхэмжлэгчид олгож шийдвэрлэлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсгийг удирдлага болгон, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Б.Дорждэрэмд холбогдох гэрээний үүрэгт 205 000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийн хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 74 дүгээр зүйлийн 74.5 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 6 800 төгрөгийг улсын төсвийн орлогод хэвээр үлдээж, хариуцагчаас 3 400 төгрөгийг, Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн 2603030349 тоот данснаас 3 400 төгрөгийг тус тус гаргуулан нэхэмжлэгчид олгосугай.

3. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд зохигч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрхгүйг тайлбарласугай.

ШҮҮГЧ



Д.МӨНГӨНТУУЛ